



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/572

Ховд

Дотуур байрны барилгын их засвар /Ховд, Мөст сум/-н
ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Эх нутгийн уулс” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Дотуур байрны барилгын их засвар /Ховд, Мөст сум/-н ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

- | | |
|------------------------------------|--|
| Ажлын хэсгийн
ахлагч: Б.Баярсүх | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга |
| Гишүүд: Д.Нямтулга | - Мэргэжлийн хяналтын газрын барилгын
техникийн хяналтын улсын байцаагч |
| Б.Түмэндэмбэрэл | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| Ц.Цолмонбаатар | - Стандарт хэмжил зүйн хэлтсийн
салбар сан хариуцсан мэргэжилтэн |
| С.Баасандорж | - Мөст сумын Засаг дарга |
| Л.Тогтохбаяр | - Мөст сумын Ерөнхий боловсролын
сургуулийн захирал |
| Б.Түмэнжаргал | - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн |
| С.Бямбасүрэн | - Барилгын зураг төслийн
“Алтайн газрын хүч” ХХК-ийн захирал |
| С.Батдорж | - Аймгийн Архивын тасгийн дарга |
| Д.Доржпүрэв | - “Эх нутгийн уулс” ХХК-ийн захирал |

2.

Нарийн бичгийн
дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга,
хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2. “Эх нутгийн уулс” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Дээрхи ажилтай холбогдолтой гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН